



87

**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2015 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/438

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжирааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" 2015 оны А/06 дугаар тушаалын Эрдэнэхуяг овогтой Билгүүнхаварт холбогдох хэсгийн "3.5 жил" гэснийг "5 жил" гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2014 оны А/219 дүгээр тушаалын хавсралт дахь Эрдэнэбат овогтой Индрад холбогдох хэсгийн "3 жил" гэснийг "4 жил" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2015 оны А/22 дугаар тушаалын хавсралт дахь Цог-Очир овогтой Галмандахад холбогдох хэсгийн "1 жил" гэснийг "2 жил" гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2013 оны А/278 дугаар тушаалын хавсралт дахь Амарсанаа овогтой Наранцээт холбогдох хэсгийн "2 жил" гэснийг "3 жил" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР